



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25

№ 954/АДН0063

Улаанбаатар хот

СНДТ-2023/225/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний геологийн алба нь өмнөх онд үүссэн 4,344,368.00 /дөрвөн сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун жаран найм/ төгрөгийн томилолтын урьдчилгаа тооцоог авч барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажилаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Он дамжсан томилолтын урьдчилгаа барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уянга, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

0001082038



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25

№ 855/А0160063

Улаанбаатар хот

снмт- 2023/225/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний геологийн алба жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн боловч ажлын хэсгээс тооллогын бүртгэл хөтөлж баталгаажуулаагүй байна. Тус ажлын хэсгийн товч тэмдэглэлд үлдэгдлийг тоолж баталгаажуулсан гэсэн боловч 92,305,800,000.00 /ерэн хоёр тэрбум гурван зуун таван сая найман зуун мянга/ төгрөгийн үндсэн болон биет бус хөрөнгө, 50,761,146.91 /тавин сая долоон зуун жаран нэгэн мянга нэг зуун дөчин зургаа/ төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5 "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авалчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уянга, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

0001082040



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25

№ 956/20160063

Улаанбаатар хот

СНПГ-2023/205/НА-СТА-Тшз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологийн судалгааны ажлаас суутган авч, зарцуулсан 2 хувийн 408,450,807.00 /дөрвөн зуун найман сая дөрвөн зуун тавин мянга найман зуун долоо/ төгрөгийн хяналтын зардлын хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өртөгт хуримтлуулан бүртгэлгүй, тайлант хугацаанд гарсан зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, мөн жилийн эцсийн байдлаар 55 гүйцэтгэгчид олгосон 69,661,703,141.00 /Жаран есөн тэрбум зургаан зуун жаран нэгэн сая долоон зуун гурван мянга нэг зуун дөчин нэг/ төгрөгийн урьдчилгааг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өгөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4 дүгээр зүйлийн 4.48 "Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Геологийн судалгааны ажлын хяналтын зардлын бүртгэлийг тодорхой болгоогүй, харилцагчид олгосон урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газард ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уянга, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261150

Z: Alban Shaardlaga 2023/0425 SNAG-33 (mk)

0001082042



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25 № 557/20160063
СН/ОГ-0023/25/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан геологийн судалгааны ажлын тодотгосон төсөв, төлөвлөгөөг мөрдөөгүй, 13 гүйцэтгэгчид 1,015,949.720.00 /нэг тэрбум арван таван сая есөн зуун дөчин есөн мянга долоон зуун хорь/ төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.

Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.9 "ҮГА нь сайдын төсвийн багцад батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрийг ГСА-д бүрэн зарцуулахын тулд төслүүдийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү дутуу гүйцэтгэсэн, ажлын санхүүжилтийг тухайн онд багтаан гүйцэтгэгч нарт олгох саналаа энэ журмын 4, 5 дугаар хавсралтын дагуу боловсруулан, өөрчлөлт, оруулах үндэслэл бүхий танилцуулга болон холбогдох нотлох баримтын хамт яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хянуулж, сайдаар батлуулан Сангийн яаманд хүргүүлнэ", 3 дугаар зүйлийн 3.1.8 "Яамны худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 3.1.6-д заасны дагуу ҮГА-аас ирүүлсэн саналыг яамны геологийн асуудал хариуцсан нэгжээр хянуулж сайдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, жагсаалтад нэгтгэн батлуулж холбогдох төрийн байгууллагуудад албажуулан хүргүүлнэ" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Геологийн судалгааны ажлын санхүүжилтийг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу санхүүжүүлээгүй, шаардлагатай тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагчаас зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүжилтийг олгоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уянга, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

0001082044



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 дугаар сарын 25

№ 558/АД16063

Улаанбаатар хот

СКПГ-2023/025/НА СТД-ТшЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний геологийн алба нь гэрээний хугацаа дуусаад 1-5 жил болсон 6,907,881,189.00 /зургаан тэрбум есөн зуун долоон сая найман зуун наян нэгэн мянга нэг зуун наян ес/ төгрөгийн 9 геологийн судалгааны ажлыг дуусгавар болгож, хүлээн авах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хугацаанд дуусгавар болоогүй, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уянга, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\IT\Km\Shaardlaga\2023\0425\5546-31.Docx

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Ахлах нягтлан бодогч Э.Мягмарсайхан
Холбоо барих утас: 70181208
Цахим шуудан: e.myagmarsaikhan@ngs.gov.mn

0001080046